



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/147

Шивээговь сум

Газар эзэмших эрхийг шилжүүлэх  
тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 38 дугаар зүйлийн 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:


1. Сумын 1 дүгээр баг, 8 дугаар байрны зүүн талд байршилтай, иргэн Боржигон овогт Баасанхүүгийн Батсүрэнгийн автогаражийн зориулалттай 21 м2 газрыг “Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээ”-ний дагуу иргэн Боржигон овогт Дувдангийн Болор-Эрдэнэд “Автогараж”-ийн зориулалтаар, тус 21 м2 газрыг 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Монгол Улсын Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хуулийг дагаж мөрдөхийг газар эзэмшигч иргэн (Дувдангийн Болор-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3. Газар эзэмшигч иргэн Дувдангийн Болор-Эрдэнэтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Э.Баярмагнай)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2014 оны А/135 дугаар захирамжийн 9 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ